

## ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

*Хэлэлцүүлгийн чиглүүлэгч:*

Д.ЗОЛБОО

*Доктор (Ph.D), дэд профессор*

*ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн захирал*

### Санал:

*Доктор Д.Эрдэнэцогт:* Монгол Улс, ОХУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойн мэндийг дэвшүүлье. Би ҮАБЗ-ийн дэргэдэх Стратеги судалгааны хүрээлэнд цэрэг стратегийн асуудлаар судалгаа хийдэг. Миний хувьд Ази-Номхон далай, Европын геостратегийн ирээдүйн нөхцөл байдлыг харахад манай хоёр орны харилцааг шинэ түвшинд гаргах нөхцөл байдал бүрэлдэж байна гэж үзэж байна. Сарын өмнө АНУ, Австрали, Их Британи Улс хамтран “АUKUS” гэх цэргийн холбоог шинээр байгууллаа. Тиймээс Австрали Улсаас эрчим хүчнийхээ 40 орчим хувийг импортоор авдаг БНХАУ-ын хувьд манай улстай харилцах бодлогоо нааштайгаар эргүүлэх боломж байна. Түүнчлэн НАТО, ОХУ-ын хоорондох асуудал хурцдаж хоёр тал харилцан төлөөлөгчийн газруудаа хаасан үйл явдал болсон. Үүнтэй холбогдуулан Монгол Улстай харилцах харилцаа, ялангуяа Монголын нутгаар дамжуулан тавих хийн хоолойн төсөл, Эдийн засгийн коридор зэрэг асуудлуудад гурван улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж нээгдэж байгаа тул энэ чиглэлд хамтран судалгаа хийж дэмжээсэй гэж та бүхнээс хүсэж байна. Энэ бол миний өөрийн санал бөгөөд Монгол-Оросын харилцааны хэтийн төлөвийг хувьдаа хэрхэн харж буйгаа та бүхэнтэй хуваалцлаа. Баярлалаа.

*Доктор Д.Золбоо:* Хоёр орны харилцааны хэтийн төлөвийн талаар өөрийн бодлоо хуваалцсан Д.Эрдэнэцогт судлаач танд баярлалаа.

*Доктор Л.Мэндсайхан:* Өнөөдрийн хуралд олон сонирхолтой илтгэлүүд тавигдаж, олон чухал санаануудыг бид сонслоо. Хоёр орны харилцааны түүх, орчин үе, хэтийн төлвийн асуудлаар эрдэмтэд маань олон аспектаар хэлэлцүүлж байна. Миний хувьд архивын салбарт хамтран ажиллах Монгол-Оросын комиссыг байгуулагдсан үеэс нь буюу 1992 оноос хойш нарийн бичгийн даргаар ажиллах хугацаанд Оросын архивуудад судалгаа хийн, боть эмхэтгэл хэвлүүлэх, Оросын архивуудын баримтуудыг хуулбарлан авах, үзэсгэлэн гаргах, харилцан баримтуудаа солилцох зэрэг ажлуудыг гүйцэтгэж ирсэн. Монгол-Оросын ХХ зууны үеийн харилцаа бол найрамдал, дайчин нөхөрлөлийн үндсэн дээрх үр дүнтэй олон талт хамтын ажиллагаа байсан гэдгийг манай судлаачид өнөөдөр олон талын баримтаар нотлон ярьж байна. Энд та бүхэнд дуулгах шинэ соргог

нэгэн мэдээ гэвэл сүүлийн үед хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагааны түүхийг судлах тухайд дорвитой ажлуудыг бид хийж эхлээд байна. Үүнд 2019 онд хэвлэгдсэн “Зөвлөлт-Монголын эдийн засгийн харилцаа (1955-1985)” архивын баримт бичгийн эмхэтгэлийг дурдаж болно. Түүнчлэн бид ОХУ-ын Төрийн архивууд дахь 1952 он хүртэлх нууцын зэрэглэлтэй баримтуудыг ил болгох ажлуудыг үе шаттай явуулж боть, эмхэтгэл болгон гаргаж байсан. Хамгийн сүүлд хоёр орны 1952 он хүртэлх улс төрийн харилцааны баримт бичгүүдийг авч, ОХУ-ын тал манайд заримыг шилжүүлэн өгч гурван боть эмхэтгэл болгон хэвлүүлсэн. 2018 оноос эхлэн хоёр талын хүчин чармайлтын дүнд ОХУ-ын Нэн шинэ түүхийн архивт буй 1952-1964 оны хоорондох Монгол-Оросын улс төрийн харилцаанд холбогдох чухал 300 орчим баримт бичгийн жагсаалтыг гаргаж мөн эмхэтгэл болгон судалгааны эргэлтэд оруулахаар шаргуу ажиллаж байна. Мөн ОХУ-ын Гадаад бодлогын төв архивт хадгалагдаж байсан баримтуудыг урьд өмнө нь манай судлаачид удаа дараа очиж хуулбарлан авч ирсэн байдаг ч судалгааны эргэлтэд хангалттай ороогүйн улмаас тус сан хөмрөг дэх 1920-1960-аад оны үеийн улс төрийн харилцааны баримтуудыг бид өөрсдийн талаас нарийвчлан судалсан. Эдгээрээс гадна Монгол Улс ЭЗХТЗ-ийн хүрээнд ЗХУ болон бусад социалист орнуудтай харилцаж байсантай холбогдох 1962 оноос хойших хугацааны 279 шинэ баримтын жагсаалтыг ОХУ-ын Эдийн засгийн төв архиваас хүлээн аваад байна. Тиймээс энэ ондоо багтаагаад Монгол-Оросын харилцааны түүхэн ойг тохиолдуулан ОХУ-ын Төрийн архивын сан хөмрөгүүдэд хадгалагдаж буй хоёр орны харилцааны түүхэнд холбогдох баримт бичгүүдийн нэгдсэн лавлах бүхий боть гаргахаар ажиллаж байгааг дуулгахын тулд эд бүгдийг та бүхэнд танилцууллаа. Анхаарал хандуулсанд баярлалаа.

*Доктор Д.Золбоо:* Танд их баярлалаа. О.Батсайхан доктор Үндэсний Архивын дарга, Л.Мэндсайхан доктор хэлтсийн дарга байсан тэр үед би залуу архивч байхдаа ОХУ-аас авсан баримтуудыг бүртгэж эргэлтэд оруулах чиглэлээр удирдлага дор нь ажиллаж байсан. Түүнээс хойш, миний анзаарснаар манайд ОХУ-аас хүлээн авч буй архивын баримт бичгүүдийг эргэлтэд оруулах тал дээр, нэн ялангуяа залуу үеийнхэнд орос хэл дээрх баримтуудыг ашиглах хандлага сул байгаа харагддаг.

*Доктор Н.Хишигт:* Тус хурлыг зохион байгуулагчдад юуны өмнө талархлаа илэрхийлье. Бид өнөөдөр Монгол-Оросын харилцааны олон зууны түүхээс сүүлийн зуун жилийн түүхийг багтаан хэлэлцсэн хурлыг хийлээ. Ийнхүү нэгэн зуун өнгөрч буй учраас энэ хугацаан дахь хоёр улсын харилцааны түүхийг бүхэлд нь нэгтгэн дүгнэсэн нэгэн том бүтээл хийх шаардлагатай байна. Мэдээжийн хэрэг 1992 оноос хойш Монгол-Оросын Засгийн газар хооронд Архивын салбарт хамтран ажиллах хүрээнд сэдэвчилсэн эмхэтгэлүүд олныг гаргасан, тэдгээрийг нь бид эдүгээ гучаад жилийн турш ашиглаж байгаа. Гэвч түүх сөхөн үзвээс 1974 онд тухайн цагийн Монгол, Зөвлөлтийн түүхчид хамтран Зөвлөлт-Монголын

харилцаанд холбогдох баримт бичгийн эмхэтгэлийг гаргаж байсан. Цаашлаад 1978, 1980 онд хоёр улсын харилцааны түүхийн монографийг бичсэнээс хойш өнөөг хүртэл дөч шахам жил боллоо.

Иймд өнөөдөр эл харилцааны нэгэн зууны түүхийг дүгнэн цэгнэж, хамтын ажиллагааны хэтийн төлөвийг хэлэлцэж байгаа энэ цагт Гадаад харилцааны яам болон Монгол Улсад суугаа ОХУ-ын Элчин сайдын яамны ажилтнуудад хандаж миний зүгээс дэвшүүлэх санал нь хоёр орны түүхчид, архивчид болон олон улсын харилцаа судлаачид нийлэн нэгдсэн томоохон хэмжээний баг Монгол Улс, ОХУ-д байгаа архивын баримтуудад тулгуурлан хоёр орны харилцааны бүрэн түүхийг зохиох ажлыг үе шаттайгаар буюу эхний ээлжинд баримт бичгийн нэгдсэн эмхэтгэлийг гаргах, түүний дараагаар нэгэн сэдэвт зохиолыг туурвих байдлаар хамтран хийх явдал байна. Залуу үеийнхний дунд эрдэм шинжилгээний түвшинд Орос хэлийг ашиглах хүмүүс цөөрч буй энэ үед аль болох цаг алдалгүй энэхүү саналыг ажил хэрэг болгоосой хэмээн хурлыг зохион байгуулагчдад уламжилъя. Та бүхэнд баярлалаа.

*Доктор Д.Золбоо:* Доктор Н.Хишигт танд баярлалаа. Таны саналыг бид бодлого боловсруулагч болон холбогдох байгууллагуудад санаачилга болгон хүргүүлэх болно.

*В.С.Зимирев:* Намайг Зимирев гэдэг, ОШУСТ-ийн ахлах зөвлөхөөр ажилладаг. Миний бие өнөөдөр эрхэм эрдэмтэн судлаач та бүхэнд хандаж “Орос хэлийг дэмжье” хэмээх уриалгыг дэвшүүлэх гэсэн юм. Өнөөдөр Монгол Улсад орос хэлний эрэлт хэрэгцээ их байгааг манай орлогч захирал өөрийн илтгэлдээ өгүүлсэн. Бид ОХУ-д тэтгэлгээр суралцах оюутныг сонгон шалгаруулахдаа орос хэлний шалгалт авдаг. Тэндээс харахад өнөөгийн хүүхэд залуучуудын орос хэлний мэдлэгийн түвшин ерөнхийдөө доогуур байгаа юм. Түүгээр үл барам зааж буй багш нарын тухайд ч тэр орос хэлтэй орчинд ажиллаж үзээгүйн улмаас мэдлэг дулимаг байна. Мөн одоо Монгол Улсад албан ёсны гадаад хэлийг англи хэлээр тогтож, орос хэлийг сургалтын хөтөлбөрөөс хасах тухай төсөл УИХ-аар оруулах гэж байгааг та бүхэн мэдсэн байх. Үүнд Орос хэлний багш нарын холбооноос онцгой бүгд хурал зарлан хэлэлцэж, албан бичгийг өргөн барьсан боловч хүчин мөхөсдөөд байгаа билээ. Иймээс энэ асуудалд өөрсдийн холбогдох чиглэлээрээ дамжуулан дэмжлэг үзүүлэхийг та бүхнээс хүсэж байна. Баярлалаа.

*Доктор Д.Золбоо:* Үнэтэй санал зөвлөмжийг дэвшүүлсэн танд баярлалаа.

*Үндэсний Төв Архивын захирал Т.Сайнжаргал:* Нийт хуралд оролцогчдод болон зохион байгуулагчдад энэ өдрийн мэнд хүргээд үр дүнтэй хурал зохион байгуулж буй явдалд талархаж байна. Би Д.Золбоо захирлын хэлсэн саналтай холбоотойгоор өөрийн саналыг хэлэх гэсэн юм. Архивын салбарт хамтран ажиллах хоёр улсын Засгийн газар хоорондын комиссын ажлын хүрээнд ОХУ-

аас хүлээн авсан баримтуудыг Үндэсний төв архивт 445 дугаартай тусгай фонд үүсгэн хадгалж байгаа. Хүмүүс хэлний бэрхшээл эсвэл бусад аливаа асуудлаас үүдэн тэнд төдийлэн очиж танилцахгүй байгаа тухай Д.Золбоо захирлын саналтай хувьдаа санал нийлж байна. Үндэсний төв архивын баримтуудаас өдгөө хэдийн эмхэтгэл болон гарсныг судлаачид маань ашиглаж байгаа. Гэхдээ манайд байгаа баримтуудын зарим нь сканнераар хуулбарлан авсан байдгийн улмаас он цагийн явцад бүдгэрч балрах шинж ажиглагдаад буй тул одооноос тэдгээрийг цахим хэлбэрээр ашиглах нөхцлийг бүрдүүлэхээр төлөвлөж байна. Үүнээс гадна Үндэсний төв архив нь баримт болон архивын хосгүй үнэт, нэн үнэт, үнэт баримтыг салбарын харьяалал, өмчийн хэлбэр, мэдээлэл агуулагчийн төрөл, хадгалагдаж байгаа байршлаас үл хамааран төвлөрүүлэн хадгалах үүрэгтэй байгууллага болохыг хуулинд заасан байдаг учир аливаа газраас ямар нэгэн баримтыг хуулбараар ч болов авсан тохиолдолд Үндэсний төв архивын сан хөмрөгт шилжүүлж байх хэрэгтэй байна. Олон нийтэд энд тэндээс ямарваа нэгэн баримт авсан талаар мэдээлдэг хэдий ч Үндэсний архивт ирэлгүй хэн нэгэн албан тушаалтанд юм уу албан байгууллагын санд хадгалагдаж үлдэх тохиолдол байдаг. Иймд мөн миний бие хуулиа даган биелүүлэхийг та бүхнээс хүсье.

Мөн Ц.Батбаяр академичийн илтгэлд дурдагдсан Монгол-Оросын худалдааны гэрээний тухайд манай архивт А-6 2-294 дугаартай нэгж бий, таныг үзсэн эсэхийг мэдэхгүй байна. Тэнд тус гэрээг байгуулах асуудлаар хоёр тал харилцсан бичиг байдаг. А-6, 101, 231, 88 зэрэг дансуудад мөн холбогдох баримт бичгүүд мэр сэр үзэгддэг тул нягталж үзвээс гэрээний эх олодох магадлалтай хэмээн бодож байна.

*Доктор Д.Золбоо:* Т.Сайнжаргал захирал танд баярлалаа.

*Доктор (Sc.D) Л.Хайсандай:* Өнөөдөр хоёр орны харилцааны түүх болон батлан хамгаалах салбарын харилцааны талаар олон сонирхолтой илтгэлүүдийг сонссон сайхан хурал боллоо. Анхаарах хамгийн чухал нэг зүйл гэвэл Монгол-Оросын харилцааны өнөөгийн асуудлуудыг ярих, хэтийн төлөвийг тодорхойлоход манай эрдэмтэн судлаачид илүүтэй төвлөрөх шаардлагатай байна. Энэ чиглэлд ГХЯ-ны Хөрш орнуудын газрын захирал Т.Батцэцэг, ОХУ-ын ЭСЯ-ны Элчин зөвлөх С.А.Краминцев, мөн доктор А.Нямдолжин нар нэлээд тодорхой ярих шиг боллоо. Ер нь одоогийн энэ нөхцөлд хоёр орны харилцааг цаашид хэрхэн хөгжүүлэх, ингэхдээ тулгуурлах гол хүчин зүйлийг тодорхойлох, ялангуяа эдийн засгийн салбарт улс төрийн харилцааг бэхжүүлэхэд судлаач бид төвлөрч ажиллах шаардлагатай. Судлаач бүр, хүрээлэн бүр тус бүртээ судалгаа хийх бус баг болон хамтарч, үзэл бодлоо нэгтгэн ажиллах нь зүйтэй гэдэг саналыг хэлье.

*Доктор Д.Золбоо:* Бидний ажилд цаашид анхаарах шаардлагатай зүйлсийг сануулан үнэтэй санал зөвлөгөөг өгсөн доктор Л.Хайсандай танд маш их баярлалаа.

Хурлын хөтөлбөрийн хуваарийн дагуу үүгээр хэлэлцүүлгээ өндөрлөж байна. Хурлын чиглүүлэгчийн хувьд хаалт болгож товчхон хэдэн үг хэлье. Өнөөдөр хэлэлцүүлсэн илтгэлүүд болон та бүхний санал зөвлөмжүүдийг нэгтгээд бид ойрын хугацаанд эмхэтгэл болгон хэвлүүлэх болно. Монгол-Оросын харилцааны эл түүхэн ойн хүрээнд эрдэм шинжилгээний гэх тодотголтой хурлыг зохион байгуулах санаачилгыг анхнаас нь дэмжиж ажилласан Гадаад харилцааны яамны удирдлага, тэр дундаа Хөрш орнуудын газрын захирал Т.Батцэцэг танд маш их талархлаа. Түүнчлэн Шинжлэх ухааны академи, Үндэсний Архивын Газар болон бусад хамтрагч байгууллагууд, илтгэл хэлэлцүүлсэн нийт эрдэмтэн судлаачдадаа чин сэтгэлийн талархал дэвшүүлж байна.

Ийнхүү энэ удаагийн эрдэм шинжилгээний хурал өндөрлөж байгааг мэдэгдье. Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.